



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuvach@audit.gov.mn](mailto:enkhtuvach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: [cheegii9989@gmail.com](mailto:cheegii9989@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	13
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв:.....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2. Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт .....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**ШААМАР СУМЫН ДУЛААНХАН  
ТОСГОНЫ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Л.ДЭЛГЭРЦЭЦЭГ ТАНАА**

2025-02-25 № СЭА-2025/119/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Боловсролын яамнаас зарласан “Ерөнхий боловсролын сургуульд цахим анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж”-ийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендерт шалгарсан Максим Консалтинг ХХК-иас 84,997.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авч хөрөнгийн орлогоор бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 89.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	272,078,242.07	323,890,362.62
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	156,268,531.96	204,365,038.32
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	156,268,531.96	204,365,038.32
3121	Төгрөг	156,268,531.96	204,365,038.32
31211	Төрийн сангийн харилцах	156,268,531.96	204,365,038.32
33	АВЛАГА	6.89	9,853,750.84
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	6.89	9,853,750.84
35	БАРАА МАТЕРИАЛ	115,809,703.22	109,671,573.46
354	Хангамжийн материал	115,809,703.22	109,671,573.46
3541	Бичиг хэргийн материал	167,000.00	467,000.00
3542	Аж ахуйн материал	30,182,675.00	25,321,020.00
3545	Барилгын засварын материал	19,082,300.00	19,082,300.00
3546	Хүнсний материал	1,084,170.00	1,373,550.00
3547	Бусад хангамжийн материал	65,293,558.22	63,427,703.46
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	613,089,305.10	777,447,509.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	613,089,305.10	777,447,509.91
392	Биет хөрөнгө	604,068,905.10	768,427,109.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	624,115,325.77	624,115,325.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	-101,997,480.42	-122,913,643.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,562,500.00	-14,562,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109,274,619.71	248,331,444.71
39206	Хуримтлагдсан элэгдэл	-90,149,172.92	-74,741,110.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,844,218.18	80,844,218.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,465,403.02	-17,084,645.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	25,999,290.22	25,999,290.22
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,541,373.92	-11,983,978.62
39217	Ном	13,988,881.50	15,860,209.50
393	Биет бус хөрөнгө	9,020,400.00	9,020,400.00
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-250,000.00	-250,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	9,020,400.00	9,020,400.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	885,167,547.17	1,101,337,872.53
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,102,337.46	77,913,916.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,102,337.46	77,913,916.00
413	Өглөг	1,102,337.46	77,913,916.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,102,337.46	
4136	Бусад өглөг		77,913,916.00
41361	Байгууллагад төлөх өглөг		77,913,916.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	884,065,209.71	1,023,423,956.53

51	Засгийн газрын хувь оролцоо	884,065,209.71	1,023,423,956.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,929.37	319,214,929.37
51101	Өмч: - төрийн	319,214,929.37	319,214,929.37
512	Хуримтлагдсан үр дүн	17,469,820.16	156,828,566.98
5121	Өмнөх үеийн үр дүн	17,469,820.16	17,469,820.16
5122	Тайлант үеийн үр дүн		139,358,746.82
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,380,460.18	547,380,460.18
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	885,167,547.17	1,101,337,872.53

## 2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

<i>/төгрөгөөр/</i>			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	939,936,213.26	1,363,818,958.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,396,763.26	115,010,904.41
120	Нийтлэг татварын бус орлого	39,396,763.26	115,010,904.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,465,958.00	3,057,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,465,958.00	3,057,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	16,591,164.50	109,650,735.71
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	18,339,640.76	2,302,668.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,539,450.00	1,248,808,054.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	839,859,100.00	1,171,835,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	839,859,100.00	1,171,835,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,680,350.00	76,972,654.26
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,680,350.00	76,972,654.26
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,427,458.55	1,224,460,211.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,427,458.55	1,224,460,211.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,660,868.55	1,164,388,081.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,409,717.11	867,180,707.94
210101	Үндсэн цалин	442,999,768.82	562,816,282.91
210102	Нэмэгдэл	138,167,190.29	269,575,502.03
210104	Урамшуулал	24,242,758.00	34,788,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,477,933.69	101,604,954.16
210201	Тэтгэврийн даатгал	52,647,215.75	68,925,054.10
210202	Тэтгэмжийн даатгал	6,191,847.94	8,695,005.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,850,658.70	4,429,291.71

210204	Ажилгүйдлийн даатгал	1,057,048.50	3,746,819.44
210205	Эрүүл мэндийн даатгал	10,731,162.80	15,808,783.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,857,537.46	60,577,316.80
210301	Гэрэл, цахилгаан	7,173,684.42	9,157,463.36
210302	Түлш, халаалт	50,333,853.04	50,333,853.44
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	1,086,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,279,902.44	10,849,060.96
210408	Бараа материал акталсны зардал	10,279,902.44	10,849,060.96
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,927,150.00	12,282,000.00
210604	Урсгал засвар	3,927,150.00	12,282,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,469,022.57	26,512,603.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,498,700.00	3,022,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,970,322.57	23,490,103.59
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,239,605.28	85,381,438.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,132,278.70	26,362,107.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,471,058.00	10,320,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,636,268.58	48,699,230.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,766,590.00	60,072,130.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,766,590.00	60,072,130.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	38,611,290.00	42,801,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,155,300.00	17,270,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	45,508,754.71	139,358,747.10
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,240,435.12	0.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,240,435.12	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		0.28
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,240,435.12	-0.28
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	39,268,319.59	139,358,746.82

### 2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	905,005,408.00	1,251,865,554.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,465,958.00	3,057,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,465,958.00	3,057,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,465,958.00	3,057,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,465,958.00	3,057,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	900,539,450.00	1,248,808,054.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	839,859,100.00	1,171,835,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	839,859,100.00	1,171,835,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,680,350.00	76,972,654.26
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,680,350.00	76,972,654.26
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	834,607,218.26	1,178,276,263.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	834,607,218.26	1,178,276,263.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	779,218,958.26	1,117,914,753.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,409,717.11	877,034,458.78
210101	Үндсэн цалин	442,158,567.87	572,670,033.75
210102	Нэмэгдэл	139,008,391.24	269,575,502.03
210104	Урамшуулал	24,242,758.00	34,788,923.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,477,940.58	101,604,947.27
210201	Тэтгэврийн даатгал	52,499,798.56	68,925,047.21
210202	Тэтгэмжийн даатгал	6,168,763.20	8,695,005.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,859,424.29	4,429,291.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,061,758.09	3,746,819.44
210205	Эрүүл мэндийн даатгал	10,888,196.44	15,808,783.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,755,200.00	61,679,654.26
210301	Гэрэл, цахилгаан	7,173,684.42	9,157,463.36
210302	Түлш, халаалт	49,231,515.58	51,436,190.90
210303	Цэвэр, бохир ус	350,000.00	1,086,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,925,150.00	15,293,000.00
210604	Урсгал засвар	3,925,150.00	15,293,000.00
2107	Томилот, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,469,022.57	26,512,603.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,498,700.00	3,022,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,970,322.57	23,490,103.59

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,181,928.00	35,790,090.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,710,870.00	25,162,590.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,471,058.00	10,627,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,388,260.00	60,361,510.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,388,260.00	60,361,510.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,232,960.00	43,090,710.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,155,300.00	17,270,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	70,398,189.74	73,589,290.36
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	38,272,600.00	25,492,784.00
	Дотоод эх үүсвэрээр	38,272,600.00	25,492,784.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,272,600.00	25,492,784.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-38,272,600.00	-25,492,784.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	32,125,589.74	48,096,506.36
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		156,268,531.96
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		204,365,038.32

## 2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	17,469,820.16	884,065,209.71
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			139,358,746.82	139,358,746.82
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,929.37	547,380,460.18	156,828,566.98	1,023,423,956.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,419,524,400.00	1,203,769,047.90	215,755,352.10	85.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,419,524,400.00	1,178,276,263.90	241,248,136.10	83.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,356,093,400.00	1,117,914,753.90	238,178,646.10	82.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,036,056,400.00	877,034,458.78	159,021,941.22	84.7
210101	Үндсэн цалин	657,986,700.00	572,670,033.75	85,316,666.25	87.0
210102	Нэмэгдэл	355,374,100.00	269,575,502.03	85,798,597.97	75.9
210104	Урамшуулал	22,695,600.00	34,788,923.00	-12,093,323.00	153.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,507,100.00	101,604,947.27	27,902,152.73	78.5
210201	Тэтгэврийн даатгал	88,064,800.00	68,925,047.21	19,139,752.79	78.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,360,600.00	8,695,005.22	1,665,594.78	83.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,180,300.00	4,429,291.71	751,008.29	85.5
210204	Ажилгүйдлийн даатгал	5,180,300.00	3,746,819.44	1,433,480.56	72.3
210205	Эрүүл мэндийн даатгал	20,721,100.00	15,808,783.69	4,912,316.31	76.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,233,000.00	61,679,654.26	2,553,345.74	96.0
210301	Гэрэл, цахилгаан	10,796,800.00	9,157,463.36	1,639,336.64	84.8
210302	Түлш, халаалт	51,436,200.00	51,436,190.90	9.10	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	1,086,000.00	914,000.00	54.3
2104	Хангамж, бараа материалын зардал			0.00	
2105	Нормативт зардал			0.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,293,000.00	15,293,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	15,293,000.00	15,293,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал			0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,566,200.00	26,512,603.59	-946,403.59	103.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,022,500.00	3,022,500.00	0.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,566,200.00	23,490,103.59	2,076,096.41	91.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,415,200.00	35,790,090.00	46,625,110.00	43.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,787,000.00	25,162,590.00	46,624,410.00	35.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,628,200.00	10,627,500.00	700.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,431,000.00	60,361,510.00	3,069,490.00	95.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,431,000.00	60,361,510.00	3,069,490.00	95.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,160,200.00	43,090,710.00	3,069,490.00	93.4
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,270,800.00	17,270,800.00	0.00	100.0

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		25,492,784.00	-25,492,784.00	
	Дотоод эх үүсвэрээр		25,492,784.00	-25,492,784.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,419,524,400.00	1,251,865,554.26	167,658,845.74	88.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,339,998,400.00	1,171,835,400.00	168,163,000.00	87.5
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,339,998,400.00	1,171,835,400.00	168,163,000.00	87.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			0.00	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	79,526,000.00	76,972,654.26	2,553,345.74	96.8
132001	Орон нутгийн төсвөөс	79,526,000.00	76,972,654.26	2,553,345.74	96.8
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			0.00	
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			0.00	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		3,057,500.00	-3,057,500.00	
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		35,000.00	-35,000.00	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		156,268,531.96	156,268,531.96	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		204,365,038.32	204,365,038.32	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Суралцагч бүрийн унших үйлийг дэмжсэн олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлж, бие даасан байдал, эерэг хандлага, жигд оролцоог хөгжүүлэхэд хамтран ажиллана” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Суралцагчдын бие даан суралцах чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх
- Багшийн ажлын байран дахь мэргэжлийн хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах
- Сургуулийн орчинд аливаа хэлбэрийн гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах

#### 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны

*болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*

- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГО, ТОЛИЛУУЛГАД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 216,170.3 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		Өөрчлөлт
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	156,268.5	204,365.0	48,096.5
Авлага	0.0	9,853.8	9,853.7
Бараа материал	115,809.7	109,671.6	(6,138.1)
Үндсэн хөрөнгө	613,089.3	777,447.5	164,358.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>885,167.5</b>	<b>1,101,337.9</b>	<b>216,170.3</b>
Өглөг	1,102.3	77,913.9	76,811.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	884,065.2	1,023,424.0	139,358.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>885,167.5</b>	<b>1,101,337.9</b>	<b>216,170.3</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 204,365.0 мянган төгрөг болж 48,096.5 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансанд 9,853.8 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн нь нягтлан бодогч төлбөр тооцоог хянаагүйгээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү шилжүүлснээс;
- Бараа материал дансны үлдэгдэл 109,671.6 мянган төгрөг болж 6,138.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 85,498.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын яамнаас 2,302.7 мянган төгрөгийн түрээсийн ном үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, цаашид ашиглах боломжгүй 12,248.7 мянган төгрөгийн хөрөнгийг сургуулийн захирлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/15 дугаар тушаалын

дагуу акталж данс бүртгэлээс хассан, үйл ажиллагаанд 81,690.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,018,983.4 мянган төгрөг болж 158,928.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 25,492.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендерт шалгарсан Максим Консалтинг ХХК-иас цахим ангийн 84,997.0 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авсан, Боловсролын яамнаас 21,170.6 мянган төгрөгийн, суманд эрх нь шилжсэн аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 15,000.0 мянган төгрөгийн, ААН иргэдээс хандивласан 19,350.8 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж зэрэг нийт 55,521.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, элэгдлээ нөхсөн ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжтой 54,129.3 мянган төгрөгийн хөрөнгийг Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 492 дугаар албан бичгийн дагуу ашиглалтын хугацааг сунгаж данс бүртгэлд тусгасан зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 241,535.9 мянган төгрөг бөгөөд 777,447.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.
- Өр төлбөр данс 77,913.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахим ангийн тоног төхөөрөмжийг урт хугацааны зээлээр авснаас шалтгаалсан байна.

### **3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,227,081.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,886.0 мянган төгрөг, нийт 1,302,967.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 256,789.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,100.0 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 1,779.2 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 970.4 мянган төгрөгөөр урсгал засварын зардлыг 6,607.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,549.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 44,524.5 мянган төгрөгөөр нийт 321,320.7 мянган төгрөгөөр бууруулж, тогтмол зардлыг 3,311.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг 984,957.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,336,975.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 79,526.0 мянган төгрөгийн, үйл ажиллагааны орлогоос 3,022.5 мянган төгрөг нийт 1,419,524.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 354,273.4 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 11,400.4 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3,022.5 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 6,081.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 41,673.5 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 22,580.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж
- Тогтмол зардлыг 4,464.5 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 1,419,524.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,203,769.0 мянган төгрөгийг зарцуулж, 204,365.0 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,203,769.0 мянган төгрөг буюу 84.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөг/</i>							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	<b>71802 Ерөнхий боловсрол</b>	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,703.6	2,703.6	-	100.0
		2	80233-Хүүхэд хамгаалал	2,874.0	2,872.4	1.7	99.9
		3	80312- Сургалт семинар	1,983.1	956.2	1,026.9	48.2
		4	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,657.7	2,139.5	518.2	80.5
		5	81801- Үдийн цай хөтөлбөр	46,160.2	43,090.7	3,069.5	93.4
		6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	18,163.5	14,083.1	4,080.4	77.5
		7	81823- Боловсролын багшийн сургалт	7,971.2	3,282.5	4,688.7	41.2
		8	81834- Боловсролын стандарт сургалт	1,200,073.3	1,002,536.9	197,536.4	83.5
		9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	50,263.3	50,056.2	207.1	99.6
		11	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	4,126.0	2,052.8	2,073.2	49.8
		12	81848-сурах бичгийн түрээс	3,022.5	3,022.5	-	100.0
		13	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	79,526.0	76,972.7	2,553.3	96.8
		<b>Нийт</b>				<b>1,419,524.4</b>	<b>1,203,769.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн цай	40,850.9	40,850.9	НТШ
	<b>Нийт дүн</b>	<b>40,850.9</b>	<b>40,850.9</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ - ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгч ирээгүй учраас “Дөлгөөн болор” ХХК-тай урьд оны гэрээг үргэлжлүүлж худалдан авалтыг гүйцэтгэжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 894,401.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,416.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь

шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 913 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд зөв тусгахтай холбоотой өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	359.1	1	359.1	100.0
Нийт дүн	1	359.1	1	359.1	100.0

#### 4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 77,913.9 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Урт хугацаат зээлээр авсан 77,913.9 мянган төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг өглөгөөр тусгаагүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3-т “бүх өр төлбөр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 9,853.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрч 1 албан шаардлага, хүргүүллээ.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Албан шаардлага

1.Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 9,853.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг үүсгээгүй	1	77,913.9	1	77,913.9			1	77,913.9				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>77,913.9</b>	<b>1</b>	<b>77,913.9</b>			<b>1</b>	<b>77,913.9</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлага үүсгэсэн	1	9,853.7			1	9,853.7						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>9,853.7</b>			<b>1</b>	<b>9,853.7</b>						



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 46/А.1850385

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 9,853.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: 4.2.1.11: “Хууль тогтоомж, .....зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүйгээс авлага үүсгэсэн зөрчлийг арилган давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Дэлгэрцэцэг, нягтлан бодогч Г.Алтанзул нарт даалг

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

432504226

**АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Шаамар сумын Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/119/НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2025/119/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	9,853,700.00
--	-------------------------	-----------	------------	----------------------------	--------------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч үгтгэ	Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 9,853.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оролдох)	4.2.1.11: "Хууль тогтоомж, .....зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал			
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.4.8		
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал			
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бараа материалын тайлан		2024 он	
2	Харилцахын баримт		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Шаамар сумын Дулаанхан тосгоны ЕБС	Захирал	Л.Дэлгэрцэцэг	99255636
				Нягтлан бодогч	Г.Алтанзул	99152998

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	11/25		
2	Аудитын менежер	11/25		

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг

1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	2/25	<i>Handwritten signature</i>
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		Гарын үсэг
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо		2025.02.24
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Шаамар сумын Дулаанхан тосгоны ЕБС
		Ажилтны	Овог нэр	Г.Алтанзул
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Пийк Ом Аудит ХХК
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		